



## Аудитын код: САГ-2018/10/СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Г.Гүнжидмаа  
Утас: 261885 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Ахлах аудитор Г.Жавхлан  
Утас: 261628 Цахим хаяг: [javkhlant@audit.gov.mn](mailto:javkhlant@audit.gov.mn)



Улаанбаатар хот

**АГУУЛГА**

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.5	Дотоод хяналт.....	6
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	7
2.9.1	Дотоод албан томилолтын зардал.....	7
2.9.2	Дотоод албан томилолтын талаар.....	7
2.9.3	Авлагын талаар.....	7
2.9.4	Өр төлбөрийн талаар .....	8
2.9.5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар .....	8
2.9.6	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар .....	8
2.9.7	Хариуцлага тооцох саналын талаар.....	8
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	8
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	9
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
2.16	Аудитаар тооцсон үр өгөөж.....	9
3	Менежментийн захидал .....	10
3.1	АВЛАГЫН ТАЛААР.....	11
3.2	ӨР ТӨЛБӨРИЙН ТАЛААР .....	12
3.3	ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР .....	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	14
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	14
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн НЭГТГЭСЭН үр дүнгийн тайлан .....	15
4.2.1	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18



## 1 Аудитын гэрчилгээ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Б.НЯМДАВАА ТАНАА

2018.03.23 № 06/321  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Нийгмийн халамжийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийгмийн халамжийн сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kheregl\Yawsan\_Bichig\2018\0323SAG42.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
021483  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig\_Kheregl\Yawsan\_Bichig\2018\0323SAG42.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 ОРШИЛ

Нийгмийн халамжийн сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай сангийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Нийгмийн халамжийн сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.


Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 03 дугаар сарын 5-наас 2018 оны 03 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, тус сангийн төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн халамжийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас Төсвийн тухай хуулийн хугацаанд багтааж 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 89/1 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### 2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Нийгмийн халамжийн сан санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон



бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/ зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тус сан нь 21 аймаг, 9 дүүргийн нийт 30 нэгжид Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангуулан ажилладаг Засгийн газрын тусгай сан юм.

Нийгмийн халамжийн сан нь Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулан, үйлчлүүлэгчдэд ёс зүйтэй мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх замаар тэдний тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авах, асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдах таатай нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

#### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Нийгмийн халамжийн сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 2 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 8 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Нийгмийн халамжийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан.

Нийгмийн халамжийн сан нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Финанс” програм хангамжаар бэлтгэсэн байна.


#### **2.5 Дотоод хяналт**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийгмийн халамжийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалттай хэмжээнд хэрэгжиж байна гэж үзлээ.

#### **2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Нийгмийн халамжийн сан 2017 оны төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангаар 323,043.7 сая төгрөгийн батлагдсан нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгээс 311,591.6 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл 96.4 хувьтай тайлагнасан байна.



Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сангийн системийн хэмжээнд нэгтгэн шалгаж үзэхэд Говьсүмбэр аймгийн Нийгмийн халамжийн сангийн 26 мэдээллийг, Ховд аймгийн Нийгмийн халамжийн сангийн 07-12 дугаар сарын мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 2 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Дотоод албан томилолтын зардал

ХХҮЕГ-ын даргын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/47 дугаар тушаалаар Дорнод аймагт насны хишиг олгож буй үйл ажиллагаатай танилцах, хяналт шалгалт, хийх, зөвлөгөө өгөх ажлаар 5 хүн томилолтоор ажилласан байна.

-Нийт томилолтын зардал 202.0 сая төгрөг зарцуулсан боловч томилолтын тайлан бичээгүй, Дорнод аймгийн ХХҮЕГ-ын тайланг баримтад хавсаргасан нь тушаалд заасан томилолтын зорилгыг хангаагүй байна.

-Мөн томилолтын зардлын тооцоогоор 13 суманд ажиллахаар тооцож зардал баталсан боловч 5 суманд ажилласан томилолтын хуудастай байна.

-Шатахууны тооцоог хянаж үзэхэд нийт 4310 км зам явж 1.5 сая төгрөгийн шатахуун зарцуулсан баримт бүрдүүлсэн боловч томилолтын хуудсаар баталгаажсан сумдын замын урт болон УБ-Чойбалсан-УБ чиглэлийн замыг оролцуулан нийт 2960 км-т 1.0 сая төгрөгийн шатахуун зарцуулсан тооцоо гарч байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

### 2.9.2 Дотоод албан томилолтын талаар

ХХҮЕГ-ын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/146 дугаар тушаалаар Дорнод аймагт Ахмад настны тухай хууль сурталчлах, аймаг, сумдын ахмадын холбооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор Халамжийн асуудал асуудал эрхэлсэн дэд дарга томилолтоор ажилласан боловч томилолтын илтгэх хуудас бичээгүй.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

### 2.9.3 Авлагын талаар

Нийгмийн халамжийн сан нь тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 0.1 сая төгрөгийн авлага шинээр үүсгэж толилуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зөв зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үүссэн авлагыг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх, ТӨСВИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

#### 2.9.4 Өр төлбөрийн талаар

Нийгмийн халамжийн сан нь тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 342.6 сая төгрөгийн өр төлбөр толилуулсан ба өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос шинээр Насны хишгийг насны ангиллаар шинээр олгож эхэлсэнтэй холбоотойгоор 156.0 сая төгрөгөөр өссөн нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

#### 2.9.5 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сангийн системийн хэмжээнд нэгтгэн шалгаж үзэхэд Говьсүмбэр аймгийн Нийгмийн халамжийн сангийн 26 мэдээллийг, Ховд аймгийн Нийгмийн халамжийн сангийн 07-12 дугаар сарын мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

#### 2.9.6 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Нийгмийн халамжийн сангийн харьяа 30 сангаас 27 халамжийн сангийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт, Багахангай дүүргийн Нийгмийн халамжийн сангийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт тус тус өгч, 2 сангийн тайланд Итгэл үзүүлсэн байна. Нийгмийн халамжийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт нийт 2,538.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 4.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөр барагдуулах акт, 15.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөрчил арилгуулах албан шаардлага тус тус тогтоож, 1,296.6 сая төгрөгийн зөрчилд 33 зөвлөмж өгч, 1,222.7 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж ажиллав. Нийт алдаа зөрчлийн 21.7 хувь буюу 552.8 сая төгрөгийн алдаа зөрчил нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, улсын төсвөөс санхүүжүүлсэн халамжийн санд, 78.3 хувь буюу 1,985.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн халамжийн санд тус тус ногдож байна. Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

#### 2.9.7 Хариуцлага тооцох саналын талаар

Төрийн аудитын байгууллагаас Багахангай дүүргийн ХХҮХ-ийн Халамжийн сангийн тайлант оны санхүүгийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын дүгнэлтээр тайлант оны санхүүгийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн Багахангай дүүргийн ХХҮХ-ийн дарга, нягтлан бодогч нарт Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д "...санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан...албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" заалтыг үндэслэн арга хэмжээ авах албан шаардлага ХХҮЕГ-ын даргад хүргүүлэх;

#### 2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

#### 2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.





## 2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Нийгмийн халамжийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт нийт 2,538.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 4.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөр барагдуулах акт, 15.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөрчил арилгуулах албан шаардлага тус тус тогтоож, 1,296.6 сая төгрөгийн зөрчилд 33 зөвлөмж өгч, 1,222.6 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж ажиллав.

Нийт алдаа зөрчлийн 21.7 хувь буюу 552.8 сая төгрөгийн алдаа зөрчил нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, улсын төсвөөс санхүүжсэн халамжийн санд, 78.3 хувь буюу 1,985.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь орон нутгийн төсвөөс санхүүжсэн халамжийн санд тус тус ногдож байна.

## 2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Нийгмийн халамжийн сангийн 2016 жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг УАГ-аас баталгаажуулж, системийн хэмжээгээр 23 зөвлөмж өгсний 21 зөвлөмжийг хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

## 2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн 311,934.1 сая төгрөгийн нийт зардлын 2 хувиар буюу 6,238.7 сая төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь, түвшин өөрчлөгдөөгүй болно.

## 2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Нийгмийн халамжийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Нийгмийн халамжийн сангийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,238.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшинг тогтоосон бөгөөд илэрсэн нийт материаллаг алдаа нь 19.3 сая төгрөг буюу материаллаг байдлын түвшингөөс даваагүй болно.

Нийгмийн халамжийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

## 2.16 АУДИТААР ТООЦСОН ҮР ӨГӨӨЖ

Нийгмийн халамжийн сангийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас Зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна. Гэвч тайлант оны санхүүгийн тайланд олгогдоогүй тэтгэмж буюу өр төлбөр өмнөх оноос 156.1 сая төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдлийг барагдуулснаар төсвийн гүйцэтгэл сайжрах, олгох ёстой тэтгэмжийн мөнгө хугацаандаа олгогдох, тус сангийн өр төлбөр буурснаар Төсвийн тухай хууль тогтоомж бүрэн хэрэгжих зэрэг 300.0 сая санхүүгийн үр өгөөж бий болно урьдчилж тооцов.



### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь нийгмийн халамжийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



### 3.1 АВЛАГЫН ТАЛААР

### Тэргүүлэх ач холбогдол №1

#### ҮАГ-ын ажиглалт

Нийгмийн халамжийн сан нь тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 0.1 сая төгрөгийн авлага шинээр үүсгэж толилуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зөв зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

#### ҮАГ-ын зөвлөмж

Үүссэн авлагыг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

#### Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах;

#### Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

### 3.2 ӨР ТӨЛБӨРИЙН ТАЛААР

#### Тэргүүлэх ач холбогдол №1

#### ҮАГ-ын ажиглалт

Нийгмийн халамжийн сан нь тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 342.6 сая төгрөгийн өр төлбөр толилуулсан ба өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос шинээр Насны хишгийг насны ангиллаар шинээр олгож эхэлсэнтэй холбоотойгоор 156.0 сая төгрөгөөр өссөн нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

#### Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бүрэн дүүрэн хэрэгжихгүй байх, тайлан бүртгэлийн үйл ажиллагаа нэгдсэн стандартаар илэрхийлэгдэхгүй байх;

#### ҮАГ-ын зөвлөмж

Өр төлбөрийг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

#### Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

### 3.3 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

#### Тэргүүлэх ач холбогдол №1

#### ҮАГ-ын ажиглалт

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сангийн системийн хэмжээнд нэгтгэн шалгаж үзэхэд Говьсүмбэр аймгийн Нийгмийн халамжийн сангийн 26 мэдээллийг, Ховд аймгийн Нийгмийн халамжийн сангийн 07-12 дугаар сарын мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн байна.

#### Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийн зарцуулалтын ил тод байдал алдагдах, Шилэн дансны тухай хууль хэрэгжихгүй байх;

#### ҮАГ-ын зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

#### Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**3.4 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

Нийгмийн халамжийн сангийн харьяа 30 сангаас 27 халамжийн сангийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт, Багахангай дүүргийн Нийгмийн халамжийн сангийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт тус тус өгч, 2 сангийн тайланд Итгэл үзүүлсэн байна. Нийгмийн халамжийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт нийт 2,538.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 4.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөр барагдуулах акт, 15.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөрчил арилгуулах албан шаардлага тус тус тогтоож, 1,296.6 сая төгрөгийн зөрчилд 33 зөвлөмж өгч, 1,222.7 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж ажиллав. Нийт алдаа зөрчлийн 21.7 хувь буюу 552.8 сая төгрөгийн алдаа зөрчил нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, улсын төсвөөс санхүүжүүлсэн халамжийн санд, 78.3 хувь буюу 1,985.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн халамжийн санд тус тус ногдож байна. Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

Төсвийн хөрөнгийн зарцуулалтын ил тод байдал алдагдах, Шилэн дансны тухай хууль хэрэгжихгүй байх;

**ҮАГ-ын зөвлөмж**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах, дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



#### 4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

##### 4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлтүүд	/мянган төгрөгөөр/	
		Оны эхний үлдэгдэл	Оны эцсийн үлдэгдэл
3.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	0.0	0.0
3.1.1.1	Кассанд багаа бэлэн мөнгө	0.0	0.0
3.1.2.1	Банкинд байгаа бэлэн мөнгө	105,737.5	247,509.9
3.1.3.1	Замд яваа мөнгөн хөрөнгө	0.0	0.0
3.1.4.1	Богино хугацаат хадгаламж	0.0	0.0
3.2.1.1	Авлага	0.0	100.0
	Урьдчилгаа тооцоо	0.0	0.0
3.4.71	Урьдчилж гарсан зардал	0.0	0.0
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	105,737.5	247,609.9
	Эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0
	Биет хөрөнгө	0.0	0.0
3.9.1.1	Биет бус хөрөнгө	0.0	0.0
	Эргэлийн бус хөрөнгийн дүн	0.0	0.0
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	105,737.5	247,609.9
<b>4.1</b>	<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>	0.0	0.0
4.1	Өр төлбөр	0.0	0.0
4.1.2.1	Төсөвт төвлөрүүлэх	0.0	0.0
4.1.3.1	Олгогдоогүй тэтгэмж	186,576.8	342,652.9
4.2.1.1	Урьдчилж орсон орлого	0.0	0.0
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төбөрийн дүн</b>	186,576.8	342,652.9
4.2.1.1	Урт хугацаат өр төлбөр	0.0	0.0
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.0	0.0
	<b>Өр төлбөрийн дүн</b>	186,576.6	342,652.9
5.1.1.1	Эздийн өмч	0.0	0.0
5.1.1.1	Засгийн газрийн сан	0.0	0.0
5.1.1.2	Хуримтлагдсан үр дүн	(80,839.1)	(95,043.)
5.1.1.3	Өмнөх оны үр дүн	77,460.6	(34,622.1)
5.1.1.4	Тайлант оны үр дүн	(158,299.7)	(60,420.9)
5.1.1.5	<b>Эздийн өмчийн дүн</b>	(80,839.1)	(95,043.)
	<b>Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	105,737.5	247,609.9



#### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлтүүд	/мянган төгрөгөөр/	
		Оны эхний үлдэгдэл	Оны эцсийн үлдэгдэл
13	Татаас ба санхүүжилтийн орлого	35,630,982.9	321,745,300.1
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /улсын төсвөөс /	35,630,982.9	321,745,300.1
	Орон нутгын төсвөөс	0.0	0.0
	Тусламжийн орлого	0.0	0.0
	Засгийн газрын нөөц сан	0.0	0.0
	Аж ахуй нэгж байгууллагын хандив, тусламж	0.0	0.0
14	Үйлчилгээний орлого	74,327.8	111,344.0
	Сангийн чөлөөт үлдэгдэлийг банкинд хадгалуулсаны хүүгийн орлого	40,703.3	65,528.9
	Бусад эх үүсвэр	33,624.6	45,815.1
<b>1</b>	<b>Сангийн орлогын дүн</b>	<b>35,705,310.7</b>	<b>321,856,644.1</b>
27	<b>Сангийн үйл ажиллагааны зардал</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	130,000.0	138,259.3
	Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	4,740,700.3	4,679,796.3
	Алдарт эхийн одонтой эхэд олгосон мөнгөн тэтгэмж	28,643,381.4	28,841,339.8
	Насны хишиг	0.0	19,921,002.0
	Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	0.0	257,652,900.0
	Банкны үйлчилгээний шимтгэл	7,675.5	11,765.8
	Дотоод албан томилот	39,626.7	25,820.1
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	46,137.0	116,114.5
	Улсын мэдээллийн маягт	98,908.7	158,746.7
	Бусдаар гүйцэтгэх нийтлэг ажил үйлчилгээ	328,336.3	388,419.2
	<b>Сангийн үйл ажиллагааны зардалын дүн</b>	<b>34,034,765.9</b>	<b>311,934,163.6</b>
	Төсөвт төвлөрүүлэх	1,828,844.6	9,982,901.4
	<b>САНГИЙН НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>35,863,610.5</b>	<b>321,917,065.0</b>
	<b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ҮР ДҮН</b>	<b>(158,299.7)</b>	<b>(60,420.9)</b>



#### 4.2.1 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>1</b>	<b>Оны эхний үлдэгдэл</b>	0.0	(80,839.1)	(80,839.1)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
<b>3</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	0.0	0.0	0.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.0	0.0	0.0
7	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	0.0
<b>8</b>	<b>Үлдэгдэл</b>	0.0	(80,839.1)	(80,839.1)
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		0.0	0.0
<b>10</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	0.0	46,217.0	46,217.0
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.0	0.0	0.0
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.0	0.0	0.0
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.0	0.0	0.0
14	Тайлант үеийн үр дүн	0.0	(60,420.9)	(60,420.9)
<b>15</b>	<b>Үлдэгдэл</b>	0.0	(95.042.9)	(95.042.9)





### 4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>Сангийн орлого</b>	<b>35,705,310.8</b>	<b>321,856,644.1</b>
1	3 Татаас ба санхүүжилтийн орлого	35,705,310.8	321,745,300.1
1	3 Улсын төсвөөс	35,630,982.9	321,745,300.1
1	3 Орон нутгын төсвөөс	0.0	0.0
1	3 Тусламжийн орлого	0.0	0.0
1	3 Засгийн газрын нөөц сан	0.0	0.0
1	3 Аж ахуй нэгж байгууллагын хандив, тусламж	0.0	0.0
1	4 Нэр зөрүүтэй гүйлгээ	0.0	0.0
1	4 Сангийн чөлөөт үлдэгдэлийг банкинд хадгалуулсаны хүүгийн орлого болон бусад орлого	74,327.8	111,344.0
<b>Сангийн орлогын дүн</b>		<b>35,705,310.7</b>	<b>321,856,644.1</b>
2	7 Төрөлжсөн асрамж үйлчилгээ	130,000.0	138,259.3
2	7 Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	4,695,459.8	4,575,701.1
2	7 Алдарт эхийн одонтой эхэд олгосон мөнгөн тэтгэмж	28,502,045.4	28,687,413.6
2	7 Банкны үйлчилгээний шимтгэл	7,675.5	11,765.8
2	7 Дотоод албан томилолт	39,626.7	25,820.1
2	7 Хичээл үйлдвэрлэлийн дадлага	46,137.0	116,114.5
2	7 Улсын мэдээллийн маягт	98,908.7	158,746.7
2	7 Бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг ажил үйлчилгээ	328,336.3	388,419.2
2	7 Насны хишиг	0.0	19,836,470.5
2	7 Хүүхдийн мөнгөн тэтгэмж	0.0	257,652,900.0
<b>Сангийн үйл ажиллагааны зардлын дүн</b>		<b>33,848,189.4</b>	<b>311,591,610.7</b>
2	7 Төсөвт төвлөрүүлсэн дүн	1,828,844.6	9,982,901.4
2	7 Урьд оны олгогдоогүй мөнгөний зарцуулалт	53,384.4	140,359.6
<b>НИЙТ САНГИЙН МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>35,730,418.3</b>	<b>321,714,871.7</b>
	Сангийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	<b>25,107.5</b>	<b>141,772.4</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>130,845.0</b>	<b>105,737.5</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>105,737.5</b>	<b>247,509.9</b>



#### 4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

1	Тайлангийн үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Тайлан оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>105,737.5</b>		
27.2	<b>Сангийн үйл ажиллагааны зардал</b>				
	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	138,260.0	138,259.3	0.7	100.0
	Ахмад дайчид Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	6,000,000.0	4,576,655.7	1,423,344.3	76.3
	Урьд оны олгогдоогүй мөнгөний зарцуулалт /ахмад/	0.0	0.0	0.0	
	Алдарт эхийн одонтой эхэд олгосон мөнгөн тэтгэмж	29,449,000.0	28,693,592.9	755,407.1	97.4
	Урьд оны олгогдоогүй мөнгөний зарцуулалт /алдарт эх/	0.0	0.0	0.0	
	Насны хишиг	20,500,000.0	19,841,102.3	658,897.6	96.8
	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	266,023,680.0	257,652,900.0	8,370,780.0	96.9
	Хичээл үйлдвэрлэлийн зардал	217,800.0	116,114.5	101,685.5	53.3
	Бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг бараа ажил үйлчилгээ	466,191.0	388,419.2	77,771.8	83.3
	Улсын мэдээлэлийн маягт бэлтгэх	198,000.0	158,746.7	39,253.3	80.2
	Дотоод албан томилолт	50,827.1	25,820.1	25,007.0	0.0
13	<b>Сангийн үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>323,043,758.10</b>	<b>311,591,610.70</b>	<b>11,452,147.40</b>	96.5
	<b>САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>323,043,758.10</b>	<b>311,818,649.60</b>	<b>11,225,108.50</b>	96.5
	<b>УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ</b>	<b>323,043,758.10</b>	<b>311,818,649.60</b>	<b>11,225,108.50</b>	96.5
	Сангийн чөлөөт үлдэгдлийн банкны хүү	0.0	0.0	0.0	
	Бусад орлогоос	0.0	0.0	0.0	
	Тохируулгын дүн	0.0	(85,266.5)	0.0	
	<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>0.0</b>	<b>247,509.9</b>	<b>0.0</b>	

